



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын театрын музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 10 нэрийн, нийт 16,916,922.00 (арван зургаан сая есөн зуун арван зургаан мянга есөн зуун хорин хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 7,950,000.00 (долоон сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Монголын театрын музейн захирал Д.Наранжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаж үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132002199

22-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
447 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНЭ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	(төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жил/
						Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	
1	Мэдрэгчтэй компьютер зааланд	2018-01-01	ш	1	3,000,000	3,000,000.00	1,500,000.00	1,500,000.00	2
2	Шилэн хорго	2013-11-25	ш	8	510,000	4,080,000.00	300,000.00	2,400,000.00	3
3	Принтер HP-12A	2018-06-12	ш	1	500,000	500,000.00	250,000.00	250,000.00	2
4	Хэвтээ цагаан тавиур	2012-07-26	ш	2	75,000	150,000.00	50,000.00	100,000.00	2
5	Чулуун суурьтай тавиур	2012-06-25	ш	4	62,500	250,000.00	50,000.00	200,000.00	2
6	Конторын ширээ	2013-09-01	ш	3	212,300	636,900.00	150,000.00	450,000.00	3
7	Файлын шүүгээ	2014-09-30	ш	3	346,998	1,040,994.00	150,000.00	450,000.00	3
8	Тавиур 1 талдаа	2014-07-15	ш	6	345,668	2,074,008.00	150,000.00	900,000.00	2
9	Тавиур 2 талдаа	2014-08-30	ш	2	691,336	1,382,672.00	250,000.00	500,000.00	2
10	Сейф	2014-05-01	ш	2	1,901,174	3,802,348.00	600,000.00	1,200,000.00	3
ДҮН						16,916,922.00 (арван зургаан сая есөн зуун арван зургаан мянга есөн зуун хорин хоёр)		7,950,000.00 (долоон сая есөн зуун тавь)	